



**МОНГОЛ УЛСЫН
ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР**

АКТ

210646 Улаанбаатар хот, Чингэлтэй дүүрэг,
Бага тойруу, Засгийн газрын IY байр,
Утас: 26-04-37, Факс: 32-32-66

2013.03.25 № 02/42 УАГ-САГ/2013/05-СТТА-ТОЛГ

ЗӨРЧЛИЙГ АРИЛГАХ ТУХАЙ

Үндэсний аудитын газрын 2013 оны бүтээгдэхүүн, ажил үйлчилгээний төлөвлөгөөний дагуу “Дулаан шарын гол” ТӨХК-ий 2012 оны санхүүгийн тайланд аудит хийлээ.

Аудитын явцад 2012 оны жилийн эцэст 17,113.8 мянган төгрөгийн нийгмийн даатгалын шимтгэлийг төсвийн жилд багтаан төсөвт төлөөгүй нь “Нийгмийн даатгалын тухай” хуулийн 16.1-д “Ажил олгогч нь даатгуулагчийн төлбөл зохих нийгмийн даатгалын шимтгэлийг түүнд хөдөлмөрийн хөлс, түүнтэй адилтгах орлого олгох бүртээ энэ хуулийн 15.1 хэсэгт заасан хувь хэмжээгээр тооцон суутгаж, тухайн сард нь багтаан нийгмийн даатгалын сангийн төвлөрсөн харилцах дансанд шилжүүлнэ” гэсэн заалтыг зөрчсөн байна.

Төрийн аудитын тухай хуулийн 15.1.12-т “аудитын явцад илэрсэн төлбөр, зөрчлийг барагдуулах акт тавих...” гэж заасныг үндэслэн **АКТ ТОГТООХ НЬ:**

- 10. НДШимтгэл 17,113.8 мянган төгрөгийг Дархан Уул аймгийн Шарын гол сумын нийгмийн даатгалын 5047035535 дугаар дансанд 2013 оны 5 дугаар сарын 1-ний дотор төвлөрүүлэх,
- 11. Тогтоосон актын төлбөрийг барагдуулах ажлыг “Дулаан Шарын гол” ТӨХК-ий захирал Б.Энхцэцэг, ерөнхий нягтлан бодогч П.Сүнжидмаа нарт хариуцуулав,
- 12. Актын биелэлтийг гаргаж, 2013 оны 5 дугаар сарын 15-ны дотор УАГ-т ирүүлэх.

АКТЫГ

ТОГТООСОН:

ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗРЫН
АХЛАХ АУДИТОР
[Signature] Л.ОДГЭРЭЛ

СИЭС АЙ АУДИТ ХХК-ИЙ
ЗАХИРАЛ

М.СЭВЖИДМАА

ЗӨВШӨӨРСӨН:

ДУЛААН ШАРЫН ГОЛ ТӨХК-ИЙ
ЗАХИРАЛ

[Signature] Б.ЭНХЦЭЦЭГ

ДУЛААН ШАРЫН ГОЛ ТӨХК-ИЙ
ЕРӨНХИЙ НЯГТЛАН БОДОГЧ

[Signature] П.СҮНЖИДМАА

